



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: huanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: Kalim_riza@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	17
.....	
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.МЕРЕЙБЕК ТАНАА

2022.02.25 № 304
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114115195.00</u>	<u>137492248.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	800000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	800000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	114115195.00	136692248.00
351	Түүхий эд материал	0.00	0.00
354	Хангамжийн материал	114115195.00	136692248.00
35410	Бичиг хэргийн материал	1431000.00	4272650.00
35420	Аж ахуйн материал	68645315.00	68301680.00
35460	Хүнсний материал	44038880.00	41401917.00
35470	үдийн хоолны материал	0.00	22716001.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2829339079.29</u>	<u>3002036945.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2829339079.29	3002036945.01
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	2793225079.29	2965997945.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	2750018080.00	2973153118.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-143060036.60	-185611388.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	256654896.00	258013896.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-227829880.89	-239825682.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	215240014.00	221990014.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-170188736.22	-176417452.26
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	13000000.00	13000000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1911890.00	1911890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	97478853.00	99783551.00
393	Биет бус хөрөнгө	36114000.00	36039000.00
39301	Програм хангамж	750000.00	750000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600000.00	-675000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35964000.00	35964000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2943454274.29</u>	<u>3139529193.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>29146875.00</u>	<u>2972248.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29146875.00	2972248.00
413	Өглөг	29146875.00	2972248.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2584025.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	26562850.00	2852248.00
4136	Бусад өглөг	0.00	120000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	120000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2914307399.29</u>	<u>3136556945.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2914307399.29	3136556945.01

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1988658085.00	1988658085.00
512	Хуримтлагдсан үр дүн	-83862498.83	138387046.89
51210	Өмнөх үеийн үр дүн	-268330568.38	-83862498.83
51220	Тайлант үеийн үр дүн	184468069.55	222249545.72
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1009511813.12	1009511813.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2943454274.29</u>	<u>3139529193.01</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,112,736,386.00	2,387,848,693.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	106,955,586.00	973,912.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,005,780,800.00	2,386,874,781.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,817,933,600.00	1,966,285,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,817,933,600.00	1,966,285,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	9,225,675.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	9,225,675.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186,847,200.00	411,363,406.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	186,847,200.00	173,101,100.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	238,262,306.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,071,462,274.45	2,165,599,147.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,071,462,274.45	2,165,599,147.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,040,495,746.45	2,118,642,547.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,474,251,839.00	1,519,532,875.00
210101	Үндсэн цалин	1,339,680,716.00	1,435,322,775.00
210104	Урамшуулал	134,571,123.00	84,210,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,216,300.00	208,626,100.00
210201	Тэтгэврийн даатгал	136,670,700.00	146,810,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,386,400.00	15,453,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,509,100.00	12,363,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,877,300.00	3,090,700.00

210205	Эрүүл мэндийн даатгал	28,772,800.00	30,907,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,847,200.00	172,101,100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,213,876.00	5,495,391.00
210302	Түлш, халаалт	181,633,324.00	166,605,709.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,307,390.00	13,474,021.00
210401	Бичиг хэрэг	1,405,700.00	2,324,925.00
210402	Тээвэр, шатахуун	4,345,290.00	1,847,596.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,943,000.00	1,749,900.00
210404	Ном, хэвлэл	117,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	630,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,595,600.00	6,921,600.00
2105	Нормативт зардал	101,767,670.00	124,961,823.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	494,400.00	2,229,687.00
210502	Хоол, хүнс	94,542,770.00	118,622,664.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,730,500.00	4,109,472.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,599,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,599,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,244,000.00	604,800.00
210702	Дотоод албан томилолт	1,244,000.00	604,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	715,000.00	1,476,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000.00	756,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,547,347.45	76,865,828.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,506,000.00	9,942,388.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,041,347.45	66,923,440.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,966,528.00	46,956,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,934,705.00	46,956,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,934,705.00	46,956,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,031,823.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,031,823.00	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,274,111.55	222,249,545.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,274,111.55	222,249,545.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,813.12	-268,330,568.38	2,729,839,329.74
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,813.12	-268,330,568.38	2,729,839,329.74
C07	Тайлант үеийн үр дүн			184,468,069.55	184,468,069.55
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,813.12	-83,862,498.83	2,914,307,399.29
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,813.12	-83,862,498.83	2,914,307,399.29
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,813.12	-83,862,498.83	2,914,307,399.29
D08	Тайлант үеийн үр дүн			222,249,545.72	222,249,545.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,813.12	138,387,046.89	3,136,556,945.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2005780800.00	2148612475.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2005780800.00	2148612475.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1817933600.00	1966285700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1817933600.00	1966285700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1000000.00	9225675.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	9225675.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	186847200.00	173101100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	186847200.00	173101100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1998748977.00	2147253475.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1998748977.00	2147253475.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1974814272.00	2078312475.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1466241172.00	1522916900.00
210101	Үндсэн цалин	1357388158.00	1438706800.00
210102	Нэмэгдэл		223200.00
210104	Урамшуулал	108853014.00	83986900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194216300.00	208626100.00
210201	Тэтгэврийн даатгал	136670700.00	146810900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14386400.00	15453800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11509100.00	12363100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2877300.00	3090700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28772800.00	30907600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185847200.00	172101100.00
210301	Гэрэл, цахилгаан	4213876.00	5495391.00
210302	Түлш, халаалт	181633324.00	166605709.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9842100.00	12044000.00
210401	Бичиг хэрэг	1554900.00	529200.00
210402	Тээвэр, шатахуун	664000.00	830000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1943000.00	1749900.00
210404	Ном, хэвлэл	1017800.00	756000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900000.00	630000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3762400.00	7548900.00
2105	Нормативт зардал	108060900.00	145781600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	494400.00	645100.00
210502	Хоол, хүнс	101600500.00	141021500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5966000.00	4115000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1000000.00	1000000.00
210604	Урсгал засвар	1000000.00	1000000.00
2107	Томилолт, зочны зардал	2120400.00	604800.00
210702	Дотоод албан томилолт	2120400.00	604800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	715000.00	1356000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15000.00	756000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700000.00	600000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6771200.00	13881975.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6771200.00	13881975.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23934705.00	68941000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23934705.00	68941000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23934705.00	68941000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7031823.00</u>	<u>1359000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>7031823.00</u>	<u>1359000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>7031823.00</u>	<u>1359000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	7031823.00	1359000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7031823.00	1359000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7031823.00	-1359000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2034977200.00	1997748977.00	2139386800.00	2139386800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2034977200.00	1997748977.00	2139386800.00	2139386800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2011042400.00	1973814272.00	2070445800.00	2070445800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1469439700.00	1466241172.00	1522916900.00	1522916900.00
210101	Үндсэн цалин	1336123300.00	1332924772.00	1438706800.00	1438706800.00
210102	Нэмэгдэл				223200.00
210104	Урамшуулал	133316400.00	133316400.00	84210100.00	83986900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194216300.00	194216300.00	208626100.00	208626100.00
210201	Тэтгэврийн даатгал	136670700.00	136670700.00	146810900.00	146810900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14386400.00	14386400.00	15453800.00	15453800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11509100.00	11509100.00	12363100.00	12363100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2877300.00	2877300.00	3090700.00	3090700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28772800.00	28772800.00	30907600.00	30907600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186706700.00	185847200.00	172101100.00	172101100.00
210301	Гэрэл, цахилгаан	4141100.00	4213876.00	4141100.00	5495391.00
210302	Түлш, халаалт	182565600.00	181633324.00	167960000.00	166605709.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19746500.00	9289100.00	12044000.00	11414000.00
210401	Бичиг хэрэг	1554900.00	1554900.00	529200.00	529200.00
210402	Тээвэр, шатахуун	830000.00	664000.00	830000.00	830000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1668300.00	1390000.00	1749900.00	1749900.00
210404	Ном, хэвлэл	1130900.00	1017800.00	756000.00	756000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	1800000.00	900000.00	630000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12762400.00	3762400.00	7548900.00	7548900.00
2105	Нормативт зардал	119768200.00	108613900.00	145781600.00	145781600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	659200.00	494400.00	645100.00	645100.00
210502	Хоол, хүнс	102153500.00	102153500.00	141021500.00	141021500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16955500.00	5966000.00	4115000.00	4115000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1000000.00	1000000.00	1000000.00	1000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210604	Урсгал засвар	1000000.00	1000000.00	1000000.00	1000000.00

2107	Томилолт, зочны зардал	2120400.00	2120400.00	604800.00	604800.00
210702	Дотоод албан томилолт	2120400.00	2120400.00	604800.00	604800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1830900.00	715000.00	1356000.00	1356000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1130900.00	15000.00	756000.00	756000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700000.00	700000.00	600000.00	600000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16213700.00	5771200.00	6015300.00	6645300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16213700.00	5771200.00	6015300.00	6645300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23934800.00	23934705.00	68941000.00	68941000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23934800.00	23934705.00	68941000.00	68941000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23934800.0	23934705.0	68941000.00	68941000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2034977200.00	1997748977.00	2139386800.00	2139386800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1847270500.00	1810901777.00	1966285700.00	1966285700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1847270500.0	1810901777.0	1966285700.00	1966285700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187706700.00	186847200.00	173101100.00	173101100.00
132001	Орон нутгийн төсвөөс	187706700.0	186847200.0	173101100.00	173101100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	125.00	132.00	119.00	125.00
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	82.0	88.0	74.00	78.00
620003	Үйлчлэх ажилтан	42.0	43.0	44.00	45.00
620004	Гэрээт ажилтан				1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1000000.00	9225675.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1000000.00	9225675.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1000000.00	9225675.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	630000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		630000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000.00	8595675.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1000000.00	8595675.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1000000.00	9225675.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	9225675.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн эрхэм зорилго нь “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх бэлтгэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 2070.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 20.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96.1 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		800.0	800.0
Бараа материал	114115.2	136692.2	225770.0
Үндсэн хөрөнгө	2829339.1	3002036.9	72697.8
Нийт хөрөнгө	2943454.3	3139529.2	96074.9
Өр төлбөр	29146.9	2972.2	26174.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2914307.4	3136556.9	222249.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2943454.3	3139529.2	96074.9

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна. Авлага дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг болж нэмэгдсэн нь цалингийн урьдчилгааны авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 136.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж оны эхнээс 22.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Аймгийн Боловсролын газраас 0.9 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн олгосон, бичиг хэргийн зүйлийн үлдэгдэл оны эхнээс 2.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, үдийн хоол болон дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний үлдэгдэл 20.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 11.6 сая төгрөгийн бичиг хэргийн зүйл, 10.5 сая төгрөгийн аж ахуйн материал, дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоолонд зориулан 171.3 сая төгрөгийн хүнсний материал, 1.8 сая төгрөгийн бусад материал, 1.5 сая төгрөгийн түлш зэргээр 195.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 0.9 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр хүлээж авч, нийт 196.8 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 174.3 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Оны эцсийн бараа материалын үлдэгдэл 136.7 сая төгрөг байгааг төрлөөр нь авч үзвэл аж ахуйн материалын үлдэгдэл 68.3 сая төгрөгийн буюу нийт үлдэгдлийн 50 хувийг, хүнсний зүйлийн үлдэгдэл 64.1 сая төгрөгийн буюу 46.9 хувийг, 3.9 хувийг бусад бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Хүүхдийн хоолны зарцуулалтыг шалгаж үзэхэд хүнсний зүйлийн орлогыг тухай бүр авч, зарцуулалтыг сарын эцэст талоны дагуу зарцуулж байсан байна. Хүүхдийн ирцийг дотуур байранд амьдарч байгаа бүх хүүхдийн нэрсийн жагсаалтад дотуур байрны багш нараар гарын үсэг зуруулж авч байгаа нь хүүхдийн тоог тулган шалгаж үзэхэд хүндрэлтэй учир байрны багш нараас тухайн өдрийн хүүхдийн тоог баталгаажуулан авч нэгтгэж байх нь зүйтэй байна.

Няравын бараа материалын тайланг сар бүр авч, орлого, зарлага, үлдэгдлийг тулган баталгаажуулж тооцоо хийгээгүйгээс хүнсний материалын орлогын дүн няравын тайлан болон санхүүгийн тайлангийн дүнгээс 18.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгааг зөрчилд тооцон зөвлөмж өгөв.

Сургууль нь оны эхэнд 44.0 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байсан ба 3 дугаар сараас эхлэн сар бүр худалдан авалт хийж, жилийн турш 116.1 сая төгрөгийн хүнсний зүйл худалдан авч, 118.4 сая төгрөгийн материалыг зарцуулж оны эцэст 41.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч хүнсний материалын их хэмжээний нөөц үүсгэсэн байна.

Хүнсний материалын оны эхний 44.0 сая төгрөгийн үлдэгдэл оны эцэст мөн хэмжээний үлдэгдэлтэй байгаагаас үзэхэд үлдэгдэл бодитой эсэх нь эргэлзээтэй байна.

Үдийн хоолны зардлыг шалгаж үзэхэд 9 дүгээр сар хүртэл үдийн цайг “Алтын-Амир” ХХК-иар гэрээгээр гүйцэтгүүлж байсан ба 9 дүгээр сараас эхлэн сургуулийн гал тогооноос үдийн хоол өгч эхэлсэн байна.

Үдийн хоолонд 2021 оны 9 дүгээр сараас 12 дугаар сарын 10-ны хооронд 55.3 сая төгрөгийн хүнсний материал худалдан авч, 32.6 сая төгрөгийн хүнсний материалыг зарцуулан оны эцэст 22.7 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 450 тоот тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх”-аар заасныг зөрчин төсвийг бүрэн зарцуулж, хүнсний материалын их хэмжээний нөөц үүсгэснийг зөрчилд тооцон тус сургуулийн 2022 оны үдийн хоолны зардлын төсвөөс төсөвт нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Дээрх байдлаар хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн нь цар тахлын хязгаарлалттай холбоотой сургуулийн үйл ажиллагаа зогсоход чанар байдлаа алдаж муудах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байгааг анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхнээс 72.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 1.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан, БШУЯ-наас 2.3 сая төгрөгийн ном үнэ төлбөргүй олгосон, ОНХС-гийн хөрөнгөөр дотуур байранд 229.2 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 6.7 сая төгрөгийн сурагчийн ширээ, сандал бэлтгэснийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж орлогод авчээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 62 тоот тогтоолоор ашиглалтын хугацаа дуусаж ашиглах боломжгүй болсон 6.1 сая төгрөгийн халуун усны байрыг данснаас хасаж актлан, үндсэн хөрөнгөд 66.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 2.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж оны эхнээс 26.2 сая төгрөгөөр буурсан байна. Оны эхэнд 2.6 сая төгрөгийн НДШ-ийн, 26.3 сая төгрөгийн хоолны, 0.3 сая төгрөгийн бусад бараа үйлчилгээний зардлын, бүгд 26.1 сая төгрөгийн өглөгийг барагдуулан, оны эцэст 3.0 сая төгрөгийн хоолны тооцооны өглөгтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 222.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 275.1 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны болон хөрөнгийн санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 94.1 сая төгрөгөөр өссөн нь ковидтой холбоотойгоор бага ангид шинээр 2 бүлэг нэмж ажиллуулсан, 6 настай хүүхдийн бие засах газрын үйлчлэгч нэмж авсан зэргээр цалин НДШ-ийн зардал 54,0 сая төгрөгөөр, нормативт зардал 23.0 сая төгрөгөөр, үдийн хоол өгөхтэй холбоотойгоор үдийн цайны зардал урьд оноос 23.0 сая төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2021 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор 2139.4 сая төгрөгөөр баталсан байна. Нийт төсвийн 1966.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 173.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор цалин, НДШ-ийн зардлыг 252.1 сая төгрөгөөр нэмж, нормативт зардлыг 117.7 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 1.0 сая төгрөгөөр бууруулж тодотгон тусгай зориулалтын дэмжлэгээс авах санхүүжилтийн хэмжээг 135.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсвийг 2139.4 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 131.3 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 32.1 сая төгрөгөөр дутуу суулгасан, 84.2 сая төгрөгийн урамшууллын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

Анх баталсан болон тодотгосон төсөвт орон тооны хязгаарыг 119 хүнээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1966.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 173.1 сая төгрөгийн нийтдээ 2139.4 сая төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2139.4 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 80.9 хувийг цалин, НДШ-ийн зардал, 8.0 хувийг тогтмол зардал, 1.8 хувийг хангамж бараа материалын зардал, 6.8 хувийг норматив зардал, 2.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсролын газраас 9.2 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч “Шинэ үе цахим хөтөлбөр”-ийн хүрээнд хөтөлбөрийн бараа бүтээгдэхүүн бэлтгэхэд 7.4 сая төгрөг, принтер худалдаж авахад 0.5 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.6 сая төгрөг, ариутгалын бодис авахад 0.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Байгууллагын сургалтын үйл ажиллагаа ковидтой холбоотойгоор танхимаар болон цахимаар явагдаж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус сургууль нь 2021 онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлуудад цалингийн зардалд 1522.9 сая төгрөг, НДШ-ийн зардалд 208.6 сая төгрөг, хүүхдийн хоолны зардалд 141.0 сая төгрөг, үдийн цайны зардалд 68.9 сая төгрөг, түлшний зардалд 166.6 сая төгрөг, нийтдээ 2108.0 сая төгрөг зарцуулсан байна.

Тус сургуулийн нийт санхүүжилт 2139.4 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 2108.0 сая төгрөгийн зардлыг хасаж 31.4 сая төгрөгийг тэвчиж болох зардал гэж үзээд Засгийн газрын тогтоолын дагуу уг зардлын 10 хувь болох 3.1 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын дагуу 3.1 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй тул зөрчилд тооцон албан шаардлага өгөв.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 116 мэдээллийг хугацаандаа оруулсан, 3 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогод санхүүжилтийн 2148.6 сая төгрөгийн 12 гүйлгээний мэдээлэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын 250.6 сая төгрөгийн 20 удаагийн халаалтын хөлс, бараа материалын үнэнд шилжүүлсэн гүйлгээг байршуулсан байна.

Оны эцэст 29.1 сая төгрөгийн өглөг үүсгэсэн мэдээлэл, 3 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна. Шилэн дансны мэдээллийн хэрэгжилтийн дундаж хувь 80% -тай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, 29.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн ба зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаандаа ирүүлжээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 98.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд илэрч 1.8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 22.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож,

3.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 70.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар бараа материалын тодруулга тайланд үдийн хоолны хүнсний материалын орлогыг 1.8 сая төгрөгөөр илүү тайлагнаж, дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материалын орлогыг мөн хэмжээгээр дутуу тайлагнасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 22.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Сургууль нь үдийн хоолны зардлын төсвийг хүүхэд өдрөөр бүрэн зарцуулсан боловч жилийн эцэст 22.7 сая төгрөгийн хүнсний материалын нөөц үүсгэсэн байна. Энэ нь сургуулийн нормативт зардлын төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнээс нормативт зардлын гүйцэтгэл, зарцуулалтад хүүхэд-өдрөөр хяналт тавьж, хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлж ажиллаагүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 450 тоот тогтоолын 4-т заасан “Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх”-аар заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нормативт зардлаас үдийн хоолны нөөц үүсгэсэн 22.3 сая төгрөгийг сургуулийг төсөөс төлүүлэх акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 3.1 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль гүйцэтгэлээр нийт 2139.4 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 31.4 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь 3.1 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Няравын бараа материалын тайланг сар бүр авч, орлого, зарлага, үлдэгдлийг тулган баталгаажуулж тооцоо хийгээгүйгээс хүнсний материалын орлогын дүн няравын тайлан болон бараа материалын тодруулга тайлангийн орлогын дүнгээс 18.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, 14.5 дахь заалтуудыг мөрдөж няравын бараа материалын тайланг сар бүр гаргуулан тооцоо хийж, орлого, зарлага, үлдэгдлийг тулган баталгаажуулж зөрчлийг арилгаж ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ажилчдад олгосон урьдчилгаа, цалин, актын төлбөр, интернетийн үйлчилгээний хөлсөнд шилжүүлсэн нийт 22.6 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэхь заалтуудыг мөрдөж зарлагын гүйлгээг өглөг дансаар дамжуулан тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансанд 29.1 сая төгрөгийн өглөг үүссэн мэдээллийг оруулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 80 хувьтай байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	6	98.1	1	1.8	1	22.7	1	3.1	3	70.6